



Урлаг судлалын ухааны Доктор (Sc.D), проф. Уран зураач, багш, М.Ш.У-ны Академийн Бага хурлын Хүмүүнлэгийн салбар чуулганы гишүүн, Орлогч дарга, 2022-оноос М.Ш.У-ны Академийн Хүмүүнлэгийн салбарт (Sc.D) хамгаалуулах зөвлөлийн Дэд дарга.

Боловсрол:

1974-1978 онд Дүрслэх урлагийн дунд сургуульд суралцсан - Театрын зураач.

1978-1979 онд Улсын цирк, Улсын драмын академик театрт зураач, 1981-онд Улсын дуурь бүжгийн академик театрт зураач.

1982-1989 онд ОХУ-ын Санкт-Петербургийн И.Е.Репиний нэрэмжит Уран зургийн академид суралцаж Зураач-багш мэргэжил эзэмшсэн.

1989-оноос МУБИС-ийн Дүрслэх урлагийн тэнхимд багш, 2007-2018 онд Тэнхимийн эрхлэгч.

2007-2010 онд МУЭ-ийн Хорооны Дэд даргын албыг хавсарч хашсан.

2007 - онд Урлаг судлалын "Шинжлэх ухааны доктор" -ын зэрэг хамгаалж, 2011 онд Профессор цол хүртсэн.

2016-2020 онд Монголын Урчуудын Эвлэлийн Удирдах зөвлөлийн гишүүн.

2020-онд М.Ш.У-ны Академийн Бага хурлын Хүмүүнлэгийн салбар чуулганы гишүүн, Орлогч дарга, 2022- оноос М.Ш.У-ны Академийн Хүмүүнлэгийн салбарт (Sc.D) хамгаалуулах зөвлөлийн Дэд дарга.

ОНЦЛОХ УРАН БҮТЭЭЛЭЭС:

1992-Урлан дахь гэр бүлийн хөрөг. МУЭ-ийн Хорооны 50 жилийн ойн үзэсгэлэнд Шилдэг бүтээлд Гутгаар байр эзэлсэн.

2001- Тусгал-1. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн.

Монголын Урчуудын Эвлэлийн Үзэсгэлэнгийн танхим.-(МУЭ-Ү.Т) 2002-Академус. уран бүтээлийн хамтарсан үзэсгэлэнг ОХУ. Москва хот. "Дом художик"-ордонд. 2009-Тусгал-2. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн. МУЭ-Үзэсгэлэнгийн танхим.

(МУЭ.Ү.Т) 2009- "Өнгө ба хар цагаан-1" үзэсгэлэнд Халуун доширок. Чулуучин Бүтээлээр, 2011- "Өнгө ба хар цагаан-2"

үзэсгэлэнд Гуталчин, Нүүрсчид бүтээлээр Дэд байр эзэлсэн.

2010 онд "Нэгэн цагт" цуврал бүтээлээр "Монголын Урчуудын Эвлэлийн нэрэмжит шагнал" хүртсэн. 2012-Тусгал-3. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн. (МУЭ-Ү.Т) 2015-"Үзэгдэл"

бүтээл "Францын өнгө" - /Франц-Монголын Дипломат харилцааны 50 жил/ үзэсгэлэнд "Тэргүүн байр". "Блю Мүүн" галерей. 2019-Монолог. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн.

(МУЭ-Ү.Т) 2022-Li Noir. Бие даасан уран бүтээлийн үзэсгэлэн. (ArtoFub. галерей) 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлтэй ба хамтарсан үзэсгэлэнд оролцож ирсэн.